



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 333

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9, 15.10, 15.13 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татварыг буцаан олгох журам"-ыг 2 дугаар хавсралтаар, "Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчид сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг явуулах журам"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. Энэ тушаалын дагуу буцааж олгох албан татвар болон урамшууллын хэмжээг тухайн сар, улирал, жилд улсын төсөвт төвлөрүүлэх тухайн төрлийн татварын 30 хувиас хэтрэхгүй байхаар тооцож тухайн жилийн улсын төсвийн төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар (Ж.Ганбат)-т даалгасугай.

Гурав. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар (Ж.Ганбат), Төрийн сангийн газар (С.Наранцогт), Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар (Х.Пүрэвсүрэн), Татварын ерөнхий газар (Б.Ариунсан)-т тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 283 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

Тав. Энэхүү тушаалыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

САЙД



Б.БОЛОР

САНГИЙН ЯАМНЫ АРХИВ  
ХУУЛБАР ҮНЭН  
Бүртгэлийн № 139  
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга  
Архивын эрхлэгч  
Нийт 27 хуудас 2015 он 12 сар 14 өдөр

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН  
ХАСАЛТ ХИЙХ, БУЦААН ОЛГОХ ТЭДГЭЭРИЙГ  
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГАХ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу нэмэгдсэн өртгийн албан татвар (цаашид “албан татвар”, эсхүл “НӨАТ” гэх)-ын хасалт хийх, албан татварыг буцаан олгох, буцаан олголтыг хянан баталгаажуулах, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэ журмын хүрээнд дараах харилцааг зохицуулна:

1.2.1. албан татвар суутган төлөгчийн төлсөн албан татварыг хасалт хийх, буцаан олгох;

1.2.2. дипломат төлөөлөгчийн болон консулын газрын албан ажлын болон тэдгээрт ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулж Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татварыг буцаан олгох.

**Хоёр. Худалдаж авсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд төлсөн албан татварын хасалт хийх**

2.1. Албан татварын хасалт (цаашид “хасалт” гэх)-ыг албан татварын падаан, гаалийн мэдүүлэг болон Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 14.1.3-т заасан этгээдийн хувьд төлбөрийн баримт зэргийг үндэслэн хийх бөгөөд дараах шалгуурыг хангасан байна:

2.1.1. албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар худалдаж авсан, эсхүл импортолсон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн байх;

2.1.2. хуульд заасны дагуу хасалт хийхийг зөвшөөрсөн бараа, ажил, үйлчилгээнд төлсөн байх;

2.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.9-д заасан хасалтыг дараах байдлаар тооцно:

2.2.1. үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэн явуулахад зориулан худалдан авсан үндсэн ба туслах материал, түүхий эд, шатахуун, тослох материал болон дулааны эрчим хүч, шуудан холбооны үйлчилгээ, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр зэргийг зориулалтын дагуу зарцуулж, тухайн үйлдвэрлэл, үйлчилгээний өртөгт шингээсэн анхан шатны баримт болон нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг үндэслэн албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээнд зарцуулсан хэсэгт ногдох албан татварыг хасах;

2.2.2.хасалтыг эрх бүхий этгээдээс баталсан үйлдвэрлэж буй бараа, бүтээгдэхүүний орц, норм, техникийн хүчин чадал, түүнд зарцуулагдах сэлбэг, шатахууны норм, нормативт үндэслэн хийнэ;

2.2.3.энэ журмын 2.2.1-д заасны дагуу хасалт хийх боломжгүй бол хасагдах албан татварын хэмжээг тодорхойлохдоо тухайн тайлангийн хугацааны албан татвар ногдох борлуулалтын орлогын дүнг мөн хугацааны борлуулалтын орлогын дүнд хувааж, нийт борлуулалтад эзлэх албан татвар ногдох борлуулалтын хувийг тодорхойлон, уг хувиар тайлангийн хугацааны худалдан авалтад төлсөн албан татварын нийт дүнг үржүүлэн, хасагдах албан татварын дүнг гаргана;

2.3. Албан татвар суутган төлөгч Хуулийн 13.1.3-д заасан бараа, ажил, үйлчилгээ борлуулсан тохиолдолд энэ журмын 2.2 дахь заалт хамаарахгүй.

2.4. Албан татвар ногдох үйлдвэрлэл үйлчилгээтэй холбоогүйгээр худалдаж авсан, эсхүл импортолсон бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татварын хасалтыг хийхгүй.

2.5. Хуулийн 14.11-д заасан шаардах эрхийг худалдан авах замаар санхүүжилт хийх гэрээний дагуу болон зээлээр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний албан татварын хасалтыг төлбөр хийсэн хуваарийг үндэслэн хийнэ.

2.6. Албан татварын хасалтыг хийхдээ зөвхөн тайлант хугацаанд хамаарах импортоор оруулсан болон худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татварыг төсөвт төлөх албан татвараас хасч тооцно.

2.7. Хуулийн 14.1-д заасны дагуу тухайн сард хийх хасалтын хэмжээ нь уг хугацаанд төлбөл зохих албан татварын дүнгээс их байвал мөн хуулийн 14.8-д заасны дагуу зохицуулна:

2.8. Энэ журмын 2.7-д заасны дагуу илүү төлсөн албан татварыг буцаан олгох, суутган тооцох харилцааг энэ журмын 3, 4 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

### **Гурав. Албан татварын буцаан олголт, суутган тооцуулалт хийлгэх**

3.1. Албан татвар суутган төлөгч нь Хуулийн 15.1.1-д заасны дагуу илүү төлсөн албан татвараа буцаан авах хүсэлт гаргана.

3.2. Энэ журмын 1.2.2-т заасны дагуу дипломат төлөөлөгчийн болон консулын газар нь тухайн сард төлсөн албан татвар буцаан авах хүсэлтээ дараах баримт бичгийн хамт бичгээр үйлдэн татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад дараа сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ:

3.2.1.энэ журмын 1-р хавсралтаар баталсан тухайн сард дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татвартай худалдан авалтын тайлан (цаашид “тайлан” гэх);

3.2.2. бараа, ажил, үйлчилгээ борлуулсан этгээд (цаашид “бэлтгэн нийлүүлэгч” гэх)-ийн үйлдсэн нэмэгдсэн өртгийн албан татварын падаан;

3.2.3. төлсөн төлбөрийн баримт;

3.2.4. буцаан олголтыг хүлээж авах нэхэмжлэх;

3.2.5. Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын хувьд Монгол Улсаас тухайн улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрыг ямар нөхцөлөөр албан татвараас чөлөөлдөг талаар тодорхойлсон Монгол Улсын Гадаад харилцааны яамны албан бичиг;

3.3. Дипломат төлөөлөгчийн болон консулын газар нь энэ журмын 3.2.1-д заасан тайланг хүргүүлэхдээ энэ журмын дагуу тухайн тайлант хугацаанд дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд бэлтгэн нийлүүлэгчээс олгосон албан татварын падааныг цахим татварын системээр шивж, илгээнэ.

3.4. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас дипломат төлөөлөгчийн болон консулын газарт албан татвар суутган төлөгчийн дугаартай адилтгах дугаар олгох бөгөөд энэ дугаарыг албан татварын тайлан, албан татварын падаанд тусгасан байна.

3.5. Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газарт ажиллагсад нь хувийн хэрэгцээндээ зориулан Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдаж авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татварыг буцаан авах хүсэлтээ өөрийн ажилладаг дипломат төлөөлөгчийн болон консулын газрын нэр дээр нэгтгэн гаргах бөгөөд албан татварын падаан дээр энэ журмын 3.4-т заасан дугаарыг бичүүлнэ.

3.6. Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу албан ажлын болон өөрийн ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулан Монгол Улсын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ нь албан татвараас чөлөөлөгдөх олон улсын байгууллагын жагсаалтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь жил бүрийн нэгдүгээр сард багтаан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

#### **Дөрөв. Төсвөөс буцаан олгох, суутган тооцох нэмэгдсэн өртгийн албан татварыг шалган баталгаажуулах**

4.1. Татварын алба энэ журмын 3.1-д заасан албан татвар суутган төлөгчийн хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан албан татварын ногдол, төлөлтийн байдлыг шалгаж, албан татварын илүү төлөлтийн дүнг баталгаажуулах актыг үйлдэн албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

4.2. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.2-т заасан дипломат төлөөлөгчийн болон консулын газрын хүсэлт, 4.1-д заасан татварын албадаас ирүүлсэн акт, саналыг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт багтаан хянаж, албан татварыг буцаан олгох, суутган тооцох эсхүл дахин хянахаар шийдвэрлэсэн тухай бичгээр буюу цахим хэлбэрээр албан татвар суутган төлөгч

буюу дипломат төлөөлөгчийн болон консулын газар (цаашид "буцаан олголт хүссэн этгээд" гэх)-т мэдэгдэнэ. Мэдэгдэлд буцаан олгохалбан татварын хэмжээ, өөрчлөгдсөн болон дахин хянах болсон үндэслэл зэргийг бичсэн байна.

4.3. Буцаан олголтыг дахин хянахаар шийдвэрлэсэн бол хяналтыг энэ тухай мэдэгдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтаан хийж, акт үйлдэнэ.

4.4. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ журмын 4.2, 4.3-т заасны дагуу хянаж, баталгаажуулсан буцаан олгохалбан татварынхүсэлтийг шийдвэрлэсэнээс хойш ажлын 2 өдөрт багтаан энэ журмын 2, 3-р хавсралтаар баталсан маягтаар гаргаж, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.5. Хэрэв албан татвар суутган төлөгч нь баталгаажуулсан буцаан олгох албан татварыг улс, орон нутгийн төсөвт төлөх бусад татварын өрөнд шилжүүлэн тооцуулах хүсэлт гаргавал татварын алба энэ журмын 4.1-д заасан журмын холбогдох этгээдийн татварын өрийн хэмжээ болон суутган тооцох татварын хэмжээг хянан баталгаажуулж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

#### **Тав. Албан татварыг буцаан олгох, бусад татварын өрөнд суутган тооцох**

5.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.4, 4.5-д заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 45 хоногт багтаан илүү төлөлтийг бусад татварын өрөнд суутган тооцох, буцаан олгох асуудлыг дараах журмаар шийдвэрлэнэ:

5.1.1.Төсвийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгж нь саналыг хүлээн авснаас хойш ажлын 40 хоногт багтаан саналыг хянаж, буцаан олголт хүссэн этгээдэд албан татвар буцаан олгох болон бусад татварын өрөнд суутган тооцох санхүүжилтийн эрхийг нээн, санхүүжилтийн мэдэгдлийг дөрөвдүгээр хавсралтын дагуу бичиж, санхүүжилт хариуцсан Төрийн сангийн нэгжид хүргүүлнэ.

5.1.2. Албан татвар буцаан олголт, суутган тооцооллыг дараах байдлаар хийнэ. Үүнд:

а.Албан татвар суутган төлөгчийн илүү төлсөн албан татвараас түүний улс, орон нутгийн төсөвт төлөх бусад татварын өрөнд суутгах суутгалыг зөвхөн харьяа татварын албадын холбогдох шатны төрийн сан дахьдансанд шилжүүлэх;

б.Албан татвар суутган төлөгчийн төсвөөс буцаан авах албан татварыг тэдгээрийн холбогдох данс руу шилжүүлэх;

в.Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газрууд, тэдгээрт ажиллагсдын дотоодын зах зээлээс худалдан авсан бараа, ажил, гүйлгээнд төлсөн албан татварыг тэдгээрийн холбогдох данс руу шилжүүлэх.

5.1.3.Төрийн сан хариуцсан нэгж нь санхүүжилтийн эрхийн мэдэгдлийн дагуу төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан албан татвар буцаан олголт, суутган тооцооллыг санхүүжүүлнэ.

5.2.Төрийн сан хариуцсан нэгж Төсвийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгж болон Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагууд бусад татварын өрөнд суутган тооцож улс, орон нутгийн төсөвт төлсөн болон албан татвар суутган төлөгч, дипломат төлөөлөгчийн болон консулын газар, тэдгээрт ажиллагсад буцаан олгосон албан татварыг дараа сарын 8-ны дотор тооцоо нийлж баталгаажуулна.

5.3. Дипломат төлөөлөгчийн болон консулын газрын ажиллагсад илүү төлсөн татвараа буцааж авахтай холбоотой дансыг буруу өгсөн бол буцсан гүйлгээг төрийн сан хариуцсан нэгж Төсвийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгжид эргэн мэдээлж, зөв дансыг өгсний үндсэн дээр дахин эрх нээнэ.

5.4. Улсын төсвөөс албан татварын буцаан олголтыг хийсэн тухай бүр татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн систем (цаашид "ТБМНС")-д буцаан олголтыг бүртгэх тухай албан бичгийг Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь татвар төлөгчийн харьяалагдах татварын албадад хүргүүлж, хяналт тавина.

### **Зургаа. Албан татварыг анхан шатны бүртгэлд тусгах**

6.1.Албан татвар суутган төлөгч нь худалдан авагч этгээдэд бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр Хуулийн 4.1.14-т заасан агуулгаар төлбөрийн баримт олгоно.

6.2.Албан татвар суутган төлөгч хоорондоо бараа, ажил, үйлчилгээ борлуулсан бол төлбөрийн баримтанд үндэслэсэн Хуулийн 4.1.13-т заасан агуулгаар албан татварын падааныг үйлдэнэ. Нэг буюу түүнээс дээш төлбөрийн баримтыг хамтатган албан татварын падааныг үйлдэж болно.

6.3.Албан татварын падааныг үндэслэн албан татвар суутган төлөгчийн тухайн тайлангийн хугацаанд хасагдах албан татварын хэмжээг тодорхойлно.

6.4.Хуулийн 14.1.3, 14.1.4-т зааснаас бусад худалдан авалтын хасалтыгалбан татварын падааныг үндэслэн хийнэ.

6.5.Хуулийн 14.1.3-д заасны дагуу төлсөн албан татварын хасалтыг албан татвар суутган төлөгчөөс олгосон төлбөрийн баримтыг, Хуулийн 14.1.4-т заасан албан татварын хасалтыг анхан шатны баримт (гарал үүслийн гэрчилгээ, эрхлэх үйл ажиллагааг нотлох бичиг баримт)-ыг тус тус үндэслэн хийнэ.

6.6.Импортын бараанд төлсөн албан татварын хасалтыг гаалийн мэдүүлгийг үндэслэнэ.

### **Долоо. Нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах**

7.1.Албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдсэн аливаа этгээд нь албан татварын ногдуулалт, хасалт, төлөлтийг тодорхойлохтой холбогдуулан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлагдсан "Мөнгөний орлогын журнал", "Мөнгөний зарлагын журнал", "Борлуулалтын журнал", "Худалдан авалтын журнал"-ыг хөтөлнө.

7.2. “Мөнгөний орлогын журнал”, “Мөнгөний зарлагын журнал”-уудад төлбөр нь мөнгөөр хийгдсэн борлуулалт болон худалдан авалтыг, “Борлуулалтын журнал”, “Худалдан авалтын журнал”-д зээлээр хийсэн борлуулалт болон худалдан авалтыг тусгах бөгөөд журналыг хөтлөхдөө “Аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн маягтыг хөтлөх аргачлал”-ыг баримтална.

7.3. “Худалдан авалтын журнал”-д бичигдсэн зээлээр хийсэн худалдан авалтанд ногдох албан татварыг “Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо” дансны ДТ-д бүртгэх бөгөөд төлбөр нь хийгдсэн тухай бүр уг дансны КТ-ээс “НӨАТ-ын тооцоо” дансны ДТ-д хаана.

7.4. “Мөнгөний орлогын журнал”, “Борлуулалтын журнал”-ыг үндэслэн борлуулсан бараа, ажил, үйлчилгээндээ ногдуулан худалдан авагчаас нэхэмжилсэн буюу тухайн тайлангийн хугацаанд ногдуулсан албан татварын хэмжээг, “Мөнгөний зарлагын журнал”-ыг үндэслэн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн буюу тухайн тайлангийн хугацаанд хасагдах албан татварын хэмжээг тус тус тодорхойлно.

7.5. Мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд өөрөө бэлтгэсэн, тариалсан үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, өндөг, арьс шир, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, түүнчлэн дотоодод үйлдвэрлэсэн гурилыг дотоодын үйлдвэрлэгчдэд борлуулсан бол үнийн дүнд нь албан татварын 10 хувь шингэсэн гэж үзэж “Мөнгөн зарлагын журнал”, “Худалдан авалтын журнал”-д бичилт хийх ба эдгээрийг хэрэглэж буй дотоодын үйлдвэрлэгч худалдан авалтын нийт үнийн дүнг 110-т хувааж, 10-аар үржүүлэн гарсан дүнгээр “НӨАТ-ын тооцоо” дансны ДТ-д, үнийн дүнг 110-т хувааж 100-аар үржүүлэн гарсан дүнгээр холбогдох бараа материалын дансны ДТ-д бичиж бүртгэнэ.

7.6. Албан татвар суутган төлөгч аливаа этгээд, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар импортолсон бараа болон бусдаас худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зарим хэсгийг албан татвар ногдох үйлдвэрлэл, үйлчилгээнд, зарим хэсгийг нь албан татвараас чөлөөлөгдсөн үйлдвэрлэл, үйлчилгээнд буюу албан татвар ногдохгүй хэрэглээнд ашиглаж байгаа бол худалдан авалтанд төлсөн албан татварын хасалтын тооцоог энэ журмын 2.3 дахь заалтын дагуу хийнэ.

7.7. Борлуулалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралттай холбогдон гарах албан татварын бууралтыг “НӨАТ-ын тооцоо” дансны ДТ-д, худалдан авалтын буцаалт, хөнгөлөлт, үнийн бууралттай холбогдох НӨАТ-ын хасалтын бууралтыг “НӨАТ-ын тооцоо” дансны КТ-д тус тус бүртгэнэ.

7.8. Барааг санхүүгийн түрээсээр худалдан авахад санхүүгийн түрээсийн төлбөр хийхээр тохирсон хуваарийг баримтлан албан татварыг ногдуулна. Хуулийн 13.5.7-д заасны дагуу санхүүгийн түрээсийн хүүг албан татвараас чөлөөлж, зөвхөн түрээсийн үндсэн төлбөрт ногдуулна. Санхүүгийн түрээсийн үндсэн төлбөр ба хүүгийн төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 17-д заасны дагуу тооцно.

7.9. Албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдсэн бэлтгэн нийлүүлэгч ба худалдан авагч этгээдийн нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг хэрхэн хийхийг дараах жишээн дээр харуулав.

**Жишээ 1:** Бөөний худалдааны “А” компани гадаадын харилцагчдаа төлбөрийг мөнгөөр хийн 2016 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр нэг бүр нь 100 ам.доллар (ам.долларын ханшийг 1USD=1000 төгрөгөөр тооцох) албан татвар ногдох үнэлгээ бүхий 100 ширхэг зурагтыг импортлосон, гаалийн байгууллагад (гаалийн мэдүүлгийн дугаар 005483) хуулийн дагуу 1,000,000 төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг 2016.4.11-ний өдрийн 75 тоот шилжүүлгээр төлсөн. Тус компани Орхон аймаг дахь жижиглэн худалдааны “Б” компанид 4 дүгээр сарын 25-ны өдөр 50 ширхэг зурагтыг 2/10, п/30 нөхцөлтэй зээлийн гэрээ байгуулан, нэг бүрийг нь 121,000 төгрөгөөр (барааны үнэ 110,000 төг, НӨАТ 11,000 төг) үнэлж, 297 дугаартай албан татварын падаан бичсэн. “Б” компани эвдрэлтэй байсан 5 ширхэг зурагтыг 5 дугаар сарын 2-нд “А” компанид буцаасан бөгөөд “А” компани буцаалтыг хүлээн зөвшөөрсөн. “Б” компани хөнгөлөлтийн хугацаанд буюу 5 дугаар сарын 4-нд 470 тоот шилжүүлгээр төлбөрөө бүрэн хийсэн. Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч хоёр албан татвар суутган төлөгчөөр бүртгүүлсэн болно.

Бараа материалыг бүртгэх байнгын системийг ашиглаж байгаа үед:

**“А” компанийн хувьд:**

	Дансны нэр	ДТ	КТ
	4-р сарын 10		
1.	Бараа /100USD*1,000Т*100ш/ Мөнгө	10,000,000	10,000,000
	5-р сарын 11		
2	НӨАТ-ын тооцоо Мөнгө	1,000,000	1,000,000
	5-р сарын 25		
3	Авлага /Б компани/ Борлуулалт /110,000Т*50ш/ НӨАТ-ын тооцоо /11,000Т*50ш/	6,050,000	5,500,000 550,000
4	Борлуулсан барааны өртөг /100,000*50ш/ Бараа	5,000,000	5,000,000
	5-р сарын 2		
5	Борлуулалтын буцаалт /110,000*5/ НӨАТ-ын тооцоо /11,000*5/ Авлага /Б компани/	550,000 55,000	605,000
6	Бараа /100,000Т*5ш/ Борлуулсан барааны өртөг	500,000	500,000
	5-р сарын 4		
7	Мөнгө Борлуулалтын хөнгөлөлт НӨАТ-ын тооцоо Авлага /Б компани/	5,336,100 99,000 9,900	5,445,000

**“Б” Компанийн хувьд:**

	Дансны нэр	ДТ	КТ
	4-р сарын 25		
1	Бараа /50ш*110,000/ Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо Өглөг /А компани/	5,500,000 55,000	6,050,000
	5-р сарын 2		
2	Өглөг /А компани/	605,000	



	Бараа /5ш*110,000Т/		550,000
	Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо /5ш*11,000Т/	55,000	
	5-р сарын 4		
3	Өглөг /А компани/	5,445,000	
	Бараа		99,000
	Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо		9,900
	Мөнгө		5,336,100
4	НӨАТ-ын тооцоо	485,100	
	Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо		485,100

Бараа материалыг бүртгэх цаг үеийн системийг хэрэглэж байгаа үед:

**“А” компанийн хувьд:**

	Дансны нэр	ДТ	КТ
	4-р сарын 10		
1	Худалдан авалт /100USD*1,000*100ш/	10,000,000	
	Мөнгө		10,000,000
	4-р сарын 11		
2	НӨАТ-ын тооцоо	1,000,000	
	Мөнгө		1,000,000
	4-р сарын 25		
3	Авлага /Б компани/	6,050,000	
	Борлуулалт /110,000Т*5/		5,500,000
	НӨАТ-ын тооцоо		550,000
	5-р сарын 2		
4	Борлуулалтын буцаалт /110,000Т*5/	550,000	
	НӨАТ-ын тооцоо	55,000	
	Авлага /Б компани/		605,000
	5-р сарын 4		
5	Авлага		5,445,000
	Борлуулалтын хөнгөлөлт /5,445,000*2%/	99,000	
	НӨАТ-ын тооцоо	9,900	
	Мөнгө	5,336,100	

**“Б” компанийн хувьд:**

	Дансны нэр	ДТ	КТ
	4-р сарын 25		
1	Худалдан авалт /50*110,000/	5,500,000	
	Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо	550,000	
	Өглөг /А компани/		6,050,000
	5-р сарын 2		
2	Өглөг	605,000	
	Худалдан авалтын буцаалт /5*110,000/		550,000
	Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо		55,500
	5-р сарын 4		
3	Өглөг	5,445,000	

	Худалдан авалтын хөнгөлөлт /5,445,000*2%/		99,000
	Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо		9,900
	Мөнгө		5,336,100
4	НӨАТ-ын тооцоо	485,100	
	Төлөгдөөгүй НӨАТ-ын тооцоо		485,100

**Жишээ 2:** Түрээслэгч компани 2016 оны 1 дүгээр сарын 1-нд түрээслүүлэгч компаниас тоног төхөөрөмж түрээслэн авсан ба түрээсийн гэрээнд дараах зүйлийг тусгасан байв. Үүнд:

1. Санхүүгийн түрээсийн хугацаа 6 жил, түрээслэгч жил бүрийн 12 дугаар сарын 31-нд 50,000 төгрөг түрээслэгчид төлнө.
2. 2016 оны 01 дүгээр сарын 01-нд түрээсийн тоног төхөөрөмжийн зах зээлийн үнэ 217,763 төгрөг байв.
3. Түрээслүүлэгчийн нуугдмал хүүгийн түвшин 10 хувь ба үүнийг түрээслэгч мэдэж байгаа.

Капиталын түрээсийн өр төлбөрийг өнөөгийн үнэ цэнээр бүртгэнэ. Үнэ цэнийг олохдоо олон удаагийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийн хүснэгтийг ашиглаж болно.

Жил бүрийн 12-р сарын 31-нд 50,000 төгрөг төлөхдөө тодорхой хэсгээр үндсэн өрийг барагдуулж, тодорхой хэсгийг нь хүүгийн төлбөрт төлж байдаг. Чухам хэд нь өр төлбөр ба хүүгийн төлбөр вэ гэдгийг тооцохдоо Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үр ашигт хүүгийн аргыг ашигладаг.

Хэрэв түрээслэгч нь түрээслүүлэгчийн ашиглаж байгаа нуугдмал хүүгийн хэмжээг мэдэж байгаа эсвэл нуугдмал хүүгийн хувь нь түрээслэгчийн хүүгээс бага байвал түрээслэгч нь нуугдмал хүүгийн түвшинг түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцохдоо ашигладаг.

#### Түрээслэгч компани Түрээсийн өр төлбөрийн элэгдүүлэлтийн хүснэгт

Огноо	Түрээсийн төлбөр	Хүүгийн зардал	Түрээсийн өрийн бууралт	Түрээсийн өрийн үлдэгдэл
(a)	(b)	(c)=e*10%	(d)	(e)
2014.01.01				217,763
2015.01.01	50,000	21,776	28,224	189,539
2016.01.01	50,000	18,954	31,046	158,493
2017.01.01	50,000	15,849	34,151	124,343
2018.01.01	50,000	12,434	37,566	86,777
2019.01.01	50,000	8,678	41,322	45,454
2020.01.01	50,000	4,545	45,455	
	30,000	82,237	217,763	

Дээрх хүснэгтээс харахад тухайн жилийн түрээсийн өр төлбөрийн эхний үлдэгдлийг 10 хувь буюу нуугдмал хүүгийн түвшнээр үржүүлсэн нь тухайн жилийн хүүгийн зардалтай тэнцүү байна. Түрээслэгч түрээсийн төлбөрийг төлөхдөө дараах журналын бичилт хийнэ. Үүнд:

Дансны нэр	ДТ	КТ
2014.01.01		
Үндсэн хөрөнгө	217,763	
Түрээсийн өглөг		197,966
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо		19,797
2015.01.01		
Хүүгийн зардал	21,776	
Хүүгийн өглөг		21,776
Түрээсийн өглөг	25,658	
Хүүгийн өглөг	21,776	
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо	2,566	
Мөнгө		50,000
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо		2,566
НӨАТ-ын тооцоо	2,566	
2016.01.01		
Хүүгийн зардал	18,954	
Хүүгийн өглөг		18,954
Түрээсийн өглөг	28,224	
Хүүгийн өглөг	18,954	
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо	2,822	
Мөнгө		50,000
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо		2,822
НӨАТ-ын тооцоо	2,822	
2017.01.01		
Хүүгийн зардал	15,849	
Хүүгийн өглөг		15,849
Түрээсийн өглөг	31,046	
Хүүгийн өглөг	15,849	
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо	3,105	
Мөнгө		50,000
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо		3,105
НӨАТ-ын тооцоо	3,105	
2018.01.01		
Хүүгийн зардал	15,849	
Хүүгийн өглөг		15,849
Түрээсийн өглөг	34,151	
Хүүгийн өглөг	12,434	
Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо	3,415	
Мөнгө		50,000

Хойшлогдсон НӨАТ-ын тооцоо		3,415
НӨАТ-ын тооцоо	3,415	

Түрээсийн хугацааны эцэст, түрээсийн өр төлбөр нь үлдэгдэлгүй болно.

**Жишээ 3:** Хүнсний үйлдвэрлэл эрхэлдэг, албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдсэн "Б" компани нарийн боов үйлдвэрлэн борлуулдаг. Тайлант сард үндсэн үйлдвэрлэлийн борлуулалтын орлого 15000,0 мян.төг, мөн хугацаанд тахианы аж ахуй эрхэлдэг албан татвар суутган төлөгчөөр бүртгэгдээгүй "С" компаниас үйлдвэрлэлийн анхан шатны боловсруулалтад ороогүй 3520,0 мян.төгрөгний өндөгний үйлдвэрлэлийн түүхий эдийн зориулалтаар худалдан авсан бол тайлант сарын албан татварын тооцоо нь:

"Б" компани нь барааг худалдан авагчид албан татвартай үнээр борлуулсан гэвэл;

Дансны нэр	Дебит	Кредит
Мөнгөн хөрөнгө /Авлага/	16500,0	
Борлуулалтын орлого		15000,0
НӨАТ-ын тооцоо		1500,0

"С" компаниас худалдан авсан өндөгийг төлбөрийг бүрэн төлж худалдан авсан гэвэл;

Бараа материал	3200,0	
НӨАТ-ын тооцоо	320,0	
Мөнгөн хөрөнгө		3520,0

### Найм. Хяналт шалгалт, хариуцлага

8.1. Энэхүү журмын хэрэгжилтэд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төсвийн бодлого, төлөвлөлт хариуцсан нэгж, Төрийн сан хариуцсан нэгж болон Татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавьж ажиллана.

8.2. Төсвөөс буцаан олгох албан татварын тооцооны үнэн зөвийг хянан баталгаажуулсан татварын алба, баримтын үнэн зөвийг албан татвар суутган төлөгч, дипломат төлөөлөгчийн болон консулын газар тус тус хариуцна.


8.3. Аудитын байгууллага хувь хүн, хуулийн этгээдийн санхүүгийн тайланг баталгаажуулахдаа албан татвартай холбоотой нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт энэ журмын дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавина.

8.4. Албан татвартай холбогдсон бүртгэлийг энэ журмын дагуу хөтлөөгүй, буруу хөтөлж төсөвт төлөх болон төсвөөс буцаан авах татварын хэмжээг зөв тодорхойлоогүй, илүү төлөлтийг буруу тодорхойлж төсвөөс нэхэмжилсэн аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.5. Буцаан олголт авах хүсэлт гаргагч этгээд нь албан татварын буцаан олголт авахтай холбогдох гомдлоо Татварын ерөнхий хуульд болон холбогдох бусад хуульд заасны дагуу гаргаж шийдвэрлүүлнэ.

---oOo---

Нэмэгдсэн өртгийн албан татварын хэсэгт хийх, буцаан авгах, тусгаарлах, нөхөн олговрын бодох бүртгэлд тусгах журмын 1 дүгээр хавсралт



Монгол Улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрын гэрээгээр төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвартай худалдан авалтын тайлан болон тэдгээрт ажиллагсдын хувийн хэрэгцээнд зориулан Монгол Улс-ын нутаг дэвсгэрт худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвартай худалдан авалтын тайлан

Татвар төлөгчийн дугаар:  
Тайлант хугацаа:  
Байгууллагын нэр:

№	Падаан үйлдсэн огноо	Падааны дахин давтагдашгүй төлбөрийн дугаар	Төлбөрийн баримтдахин давтагдашгүй дугаар	Бэлтгэн нийлүүлэгчийн нэр	Регистрийн дугаар	Бараа, ажил, үйлчилгээний нэр	Бараа, ажил, үйлчилгээний Код	Бараа, ажил, үйлчилгээний дүн	НӨАТ (төр)	Хянас ан
<b>НИЙТ ДҮН</b>										


Тайланг шалгаж, буцаан олгох НӨАТ-ын баталгаажуулалт хийсэн: ..... / .....

Тэмдэг  
Баталгаажуулсан буцаан олголтын дүн: ..... /Тоогоор/  
..... /Үсгээр/  
..... /Үсгээр/

Огноо:



Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох тусгай жуурын 3 дугаар хавсралт



..... ОНЫ ..... ДУГААР САРД ДИПЛОМАТӨЛӨӨЛГӨЧИЙН ГАЗРУУД, ТЭДГЭЭРТ АЖИЛЛАГСДАД БУЦААН ОЛГОХ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ЖАГСААЛТ

/Төгрөгөөр/

№	Нэр	Хамруулсан хугацаа	Харилцах банк	Дансны дугаар	Буцаан олгох НӨАТ-ын дүн

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

ТАТВАРЫН ГАЗАР, ХЭЛТСИЙН ДАРГА

..... /

ТАТВАРЫН УЛСЫН БАЙЦААГЧ:

..... /

..... ОНЫ ..... САРЫН ..... -НЫ ӨДӨР

Нэмэгдсэн өртгийн албан татварын буцаан олголт олгох санхүүжилтийн мэдэгдэл № ...-ий өдөр  
 Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох мэдээг үйлс нэмэгдсэн өртгийн албан татварын бодох бүртгэлд тусгах журмын 4 дүгээр хавсралт



ТАНИЛЦАВ. САНГИЙН САЙД

Санхүүжилтийн мэдэгдэл №

Хувь-

20.. оны ... дугаар сарын ...-ний өдөр

№	Байгууллага, аж ахуйн нэгжийн нэр, харилцдаг татварын алба	Гүйлгээний утга	Регистрийн дугаар	Харилцагч банк	Дансны дугаар	Мөнгөний дүн (төгрөгөөр)
Бүлэг						
Бүлгийн дүн						
НИЙТ ДҮН						

ХЯНАСАН:

ТБТГ-ын дарга  
 ТОХ-ийн дарга

Мэдэгдэл  
 бичсэнхариуцсан  
 мэргэжилтэн



## НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ХУДАЛДАН АВАЛТАД ТӨЛСӨН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫГ БУЦААН ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч (цаашид “албан татвар төлөгч” гэх) -ийн худалдан авалтад төлсөн нэмэгдсэн өртгийн албан татвар (цаашид “албан татвар” гэх)-ын 20 хүртэлх хувийг буцаан олгох болон түүнтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Энэ журамд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан нэр томъёог хэрэглэнэ.

### Хоёр. Хамрах хүрээ

2.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан зориулалтаар бараа, ажил, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөс худалдан авсан хувь хүнд энэ журам хамаарна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан зориулалтаар худалдан авсан бараа, ажил, үйлчилгээ нь албан татвараас чөлөөлөгдсөн бол энэ журамд хамаарахгүй.

### Гурав. Албан татварыг буцаан олгох нөхцөл

3.1. Албан татварыг буцаан олгоход дараах нөхцөлийг нэгэн зэрэг хангасан байх шаардлагатай:

3.1.1. албан татвар төлөгчийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний зориулалт нь энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан байх;

3.1.2. албан татвар суутган төлөгчөөс албан татвар ногдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байх;

3.1.3. татварын албанд бүртгэгдсэн худалдан авалтын мэдээлэл нь төлбөрийн баримтын агуулгаар бүртгэлийн хэрэгсэл, бүртгэлийн машин, нэгдсэн болон хэрэглэгчийн системд бүртгэгдсэн байх;

3.1.4. албан татвар төлөгч болон албан татвар суутган төлөгчийн бүртгүүлсэн төлбөрийн баримтын мэдээлэл нь баталгаажсан байх;

3.1.5. албан татвар төлөгч нь нэгдсэн системд бүртгэгдсэн байх.

3.2. Энэ журмын 3.1.4-д заасан төлбөрийн баримтын мэдээлэл баталгаажсан гэдэг нь нэгдсэн систем дэх худалдан авалтын бүртгэлийн мэдээллийг албан татвар төлөгч болон албан татвар суутган төлөгчийн оруулсан мэдээлэл харилцан нийцэж бүртгэгдсэн байхыг ойлгоно.

#### **Дөрөв. Албан татвар төлөгч буцаан олголтод хамрагдах**

4.1. Албан татвар төлөгч нь энэ журмын зорилгоор төлсөн албан татварынхаа 20 хүртэлх хувийг буцаан авах хүсэлтэй бол нэмэгдсэн өртгийн албан татварын нэгдсэн системийн хэрэглэгчийн хэсэг (цаашид “хэрэглэгчийн хэсэг” гэх)-т нэвтрэн, системийн өгөгдлийн дагуу дараах мэдээллийг бүртгүүлнэ. (Энэхүү хэрэглэгчийн хэсгийн тусламжтайгаар албан татвар төлөгч нь төлсөн албан татвар болон буцаан авах албан татварын хэмжээгээ хянах боломжтой)

4.1.1. Хэрэглэгчийн овог, нэр;

4.1.2. регистрийн дугаар;

4.1.3. цахим шуудан /имэйл/-ийн хаяг;

4.1.4. утасны дугаар;

4.1.5. албан татварын буцаан олголтоо авах Монгол Улсад бүртгэлтэй банк, дансны дугаар.

4.2. Албан татвар төлөгч нь буцаан олголтод хамрагдахын тулд дараах нөхцөлийг хангасан байна:

4.2.1. албан татвар суутган төлөгчөөс бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай бүр худалдан авалтаа нотолсон төлбөрийн баримтыг цаасан эсхүл цахим хэлбэрээр авсан байх;

4.2.2. төлбөрийн баримтын мэдээллийг хэрэглэгчийн хэсэг дэх өөрийн бүртгэлдээ худалдан авалт хийснээс хойш 15 (арван тав) хоногийн дотор бүртгүүлж баталгаажуулсан байх;

4.2.3. алба татвар төлөгчийн энэ журмын 4.1.5-д заасан мэдээлэл зөрүүтэй талаар нэгдсэн системээс мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд мэдээллийг арван тав /15/ хоногийн дотор засварлах.

4.3. Албан татвар төлөгч нь энэ журмын 4.2.1-т заасан төлбөрийн баримтын мэдээлэл нь баталгаажихгүй бол энэ талаар нэгдсэн системээр дамжуулан татварын албанд мэдэгдэнэ.

4.4. Төлбөрийн баримтын дүнд өөрчлөлт орсон тохиолдолд 15 хоногийн хугацаанд багтаан холбогдох өөрчлөлтийг албан татвар төлөгч хэрэглэгчийн хэсэгт, харин албан татвар суутган төлөгч нь бүртгэлийн машин, хэрэгслээрээ дамжуулан нэгдсэн системийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлтийг оруулсан байна.

#### **Тав. Албан татвар суутган төлөгчийн эрх, үүрэг**

5.1. Албан татвар суутган төлөгч нь хэрэглэгчийн системийг заавал ашиглана.

5.2. Албан татвар суутган төлөгч нь бараа, ажил, үйлчилгээ борлуулсан тухай бүрт албан татвар төлөгчид стандартын шаардлага хангасан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.14-т заасан төлбөрийн баримтыг заавал өгч, мэдээллийг тухай бүр нэгдсэн системд дамжуулна.

5.3. Албан татвар суутган төлөгчийн техникийн нөхцөлөөс хамаарч энэ журмын 5.2-т заасан мэдээллийг тухай бүр дамжуулах боломжгүй бол 3 хоног тутамдамжуулахүүрэгтэй.

5.4. Татварын албанаас төлбөрийн баримтын мэдээллийг нэгдсэн системд дамжуулахыг шаардсан тохиолдолд албан татвар суутган төлөгч ажлын 3 хоногийн дотор холбогдох мэдээллийг нэгдсэн системд дамжуулна.

5.5. Албан татвар суутган төлөгч нь хэрэглэгчийн систем ашиглах боломжгүй нөхцөл байдал үүссэнээс нэгдсэн системд шууд мэдээлэл дамжуулах боломжгүй болсон буюу төлбөрийн баримтыг хэвлэх, мэдээлэл дамжуулах боломжгүй болсон тохиолдолд холбогдох гүйлгээний мэдээллийг албан татвар төлөгчид бүрэн хүргүүлж, 7 хоногийн дотор уг мэдээллийг нэгдсэн системд дамжуулна.

### **Зургаа. Албан татвар буцаан олгох**

6.1. Тухайн жилд буцаан олгох албан татварын хувь, хэмжээг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15.13-д заасныг үндэслэн тухайн жилийн төсвийн төсөлд тусгасан хувь, хэмжээгээр тооцож олгоно.

6.2. Албан татвар төлөгчийн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн албан татварын буцаан олголтыг жилд нэг удаа түүний хэрэглэгчийн хэсэгт бүртгүүлсэн буцаан олголт авах дансанд олгоно.

6.3. Татварын алба нь тухайн жилийн буцаан олголтын дүнг дараа жилийн эхний сарын 15-ны дотор албан татвар төлөгч бүрээр нэгдсэн системээс баталгаажуулан гаргасан мэдээллийг хянаж тэмдэглэл үйлдэн албан татварыг буцаан олгуулах саналын хамт татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

6.4 Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу буцаан төлөх татварын хэмжээний саналыг ажлын 7 өдөрт багтаан хянан баталгаажуулж, албан татвар буцаан олгох саналыг ажлын 2 өдөрт багтаан Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан бичгээр ирүүлнэ. Төрийн сангийн нэгж Улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан санхүүжилтийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тусгай дансанд ажлын 45 хоногийн дотор санхүүжүүлнэ.

6.5. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүжилт орсоноос хойш ажлын 3 өдөрт багтаан Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу Төлбөрийн хүсэлт /ТТ1 маягт/ болон файлыг Төрийн санд ирүүлж гүйлгээг хийнэ. Төлбөрийн хүсэлтэд доорх мэдээллийг үнэн зөв, гүйцэд бөглөсөн байна.

- Хүлээн авагчийн нэр;
- Хүлээн авагчийн регистрийн дугаар;
- Хүлээн авагчийн банк;
- Хүлээн авагчийн дансны дугаар;
- Мөнгөн дүн.

6.6.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтанд төлсөн албан татварын 20 хүртэлхувийн албан татварын буцаан олголтыг Төрийн сан дахь тусгай дансаар дамжуулан хүлээн авагчийн дансанд шилжүүлнэ.

6.7. Албан татвар төлөгчийн буцаан олголт хүлээн авах банк, дансны дугаар зөрүүтэйн улмаас гүйлгээ хийгдээгүй тохиолдолд нэгдсэн системээс албан татвар төлөгчид мэдэгдэл хүргүүлнэ.

6.8.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албан татвар төлөгчид мэдэгдэл хүргүүлснээс хойш 30 хоногийн дараа залруулгын гүйлгээний хүсэлтийг Төрийн санд хүргүүлнэ.

6.8. Төрийн сан Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн худалдан авалтанд төлсөн татварын 20 хүртэл хувийн албан татварын буцаан олголтын мөнгөн дүн, бүртгэгдсэн банкны дансны мэдээллийг хариуцахгүй болно.

6.9.Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улирал бүрийн эцэст тооцоо хийж тусгай данс үлдэгдэлтэй бол санхүүжилт хийсэн дансруу буцаан төвлөрүүлнэ.

6.10.Албан татвар төлөгч нь буцаан авалтаа авсаны дараа энэ журмын 4.4-т заасны дагуу төлбөрийн баримтын дүнд өөрчлөлт орсоны улмаас буцаан авалтын дүнд өөрчлөлт орж, албан татвар төлөгчид татварын өр үүсч байгаа бол татварын алба энэ талаар албан татвар төлөгчид мэдэгдэж илүү авсан буцаан олголтыг буюу шинээр үүссэн өрийг нөхөн төлүүлэх эсхүл дараагийн хугацаанд буцаан авах албан татвараас суутган тооцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

---oOo---

## СУГАЛААНЫ ТОХИРЛООР УРАМШУУЛАЛ ОЛГОХ, ТҮҮНИЙГ ЯВУУЛАХ ЖУРАМ

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Сугалааны тохирлоор урамшуулал олгох, түүнийг зохион байгуулахтай холбогдох харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Сугалаа явуулах үйл ажиллагааг зохион байгуулахдаа Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (цаашид “хууль” гэх) болон Монгол Улсын холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

### Хоёр. ХАМРАХ ХҮРЭЭ

2.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-т заасан хэрэглэгчийн системтэй этгээдээс (цаашид “борлуулагч” гэх) хуулийн 5.1-д заасан зориулалтаар худалдан авалт хийсэн хувь хүнд (цаашид “сугалаанд оролцогч” гэх) энэ журам хамаарна.

### Гурав. СУГАЛААНЫ ТОХИРЛЫН УРАМШУУЛАЛ ОЛГОХ НӨХЦӨЛ

3.1. Сугалаанд оролцогч нь дараах нөхцөлийг хангасан байна:

3.1.1. Хуулийн 4.1.20-д заасан нэгдсэн системийн хэрэглэгчийн хэсэгт (цаашид “хэрэглэгчийн хэсэг” гэх) өөрийн овог, нэр, регистрийн дугаар, цахим шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар болон Монгол Улсад бүртгэлтэй банкны нэр, дансны дугаарыг бүртгүүлсэн байх;

3.1.2. Борлуулагчаас бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан байх;

3.1.3. Энэхүү журмын 3.1.2-т заасан худалдан авалтыг нотлох нэгдсэн системээс үүсгэсэн сугалааны дугаарын мэдээлэл агуулсан төлбөрийн баримтыг (цаашид “сугалааны тасалбар” гэх) авсан байх;

3.1.4. Сугалааны тасалбарыг хэрэглэгчийн хэсгийн бүртгэлд худалдан авалт хийгдсэн өдрөөс хойш 15 (арван тав) хоногийн дотор бүртгүүлсэн байх;

3.2. Сугалааны тасалбар дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1. Нэгдсэн системээс үүсгэсэн сугалааны дугаарын мэдээллийг (цаашид “сугалааны дугаар” гэх) агуулсан байх;

3.2.2. Хуулийн 4.1.14-т заасан төлбөрийн баримтын мэдээллийг агуулсан байх;

3.2.3. Нэгдсэн системээс олгосон шифрлэсэн нууцлалын QR кодтой байх;

3.3. Борлуулагч дараах үүрэгтэй байна:

3.3.1. Бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүр хэрэглэгчийн системд бүртгэж сугалааны тасалбарыг сугалаанд оролцогчид олгох;

3.3.2. Сугалааны дугаарыг зөвхөн сугалаанд оролцогчид олгох сугалааны тасалбарын хувь дээр хэвлэх;

3.3.3. Сугалааны тасалбарын мэдээллийг тухай бүр, эсхүл 3 хоногийн дотор нэгдсэн системд үнэн зөв, бүрэндамжуулсан байх;

3.4. Нэгдсэн системд баталгаажуулсан тухайн төлбөрийн баримтаар худалдан авсан бараа, ажил үйлчилгээг буцааж, нийт төлбөрийг хүлээн авсан татвар төлөгч буюу сугалаанд оролцогч нь нэгдсэн системийн хэрэглэгчийн хэсэгт, нийт төлбөрийг буцаан олгосон татвар суутган төлөгч буюу борлуулагч нь бүртгэлийн машин, хэрэгслээрээ дамжуулан нэгдсэн системийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлтийг энэ журамд заасан хугацаанд багтаан оруулсанаар тухайн сугалааны тасалбар бүхий төлбөрийн баримтыг хүчингүйд тооцно .

3.5. Нэгдсэн системд баталгаажуулаагүй тухайн төлбөрийн баримтаар худалдан авсан бараа, ажил үйлчилгээг буцааж, нийт төлбөрийг буцаан олгосон татвар суутган төлөгч буюу борлуулагч нь бүртгэлийн машин, хэрэгслээрээ дамжуулан нэгдсэн системийн мэдээллийн санд холбогдох өөрчлөлтийг энэ журамд заасан хугацаанд багтаан оруулсанаар тухайн сугалааны дугаар бүхий төлбөрийн баримтыг хүчингүйд тооцно.

3.6. Энэ журмын 3.4-д заасны дагуу сугалааны тасалбар хүчингүй болохоос өмнө сугалааны тохирол таарч урамшуулал хожсон бол сугалаанд оролцогчид урамшууллыг олгоно.

### **Дөрөв. СУГАЛААНЫ ТОХИРОЛ ЯВУУЛАХ ЗАРЧИМ**

4.1. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.11-т заасан нэгдсэн систем хариуцагч нь сард нэгээс багагүй удаа сугалааны тохирол явуулах бөгөөд сугалаа нь супер болон үндсэн урамшууллын тохиролтой байна.

4.2. Сугалааны тохирол явуулах үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод, шударга байх зарчмыг хангасан байна.

4.3. Сугалааны тасалбарт агуулагдах сугалааны дугаарыг зөвхөн нэгдсэн системээс олгоно.

4.4. Сугалааны дугаар нь хоёр /2/ латин том үсэг болон тэг /0/-ээс ес /9/ хүртэлх найман /8/ цифр бүхий тооноос бүтсэн AA00000000 дугаарлалтаас ZZ99999999 дугаарлалтын хооронд байна. Сугалааны дугаарын 2 үсэг нь дахин давтагдашгүй серийн дугаарыг илэрхийлнэ.

4.5. Үндсэн болон супер сугалааны тохирлыг сугалааны машинаас найман бөмбөлөг санамсаргүй байдлаар тус тус үлээлгэн гаргах замаар

хөндлөнгийн хяналтын дор зохион байгуулна. Бөмбөлөгийн дугаарлалт нь 0-ээс 9 хүртэлх 10 цифрээс бүрдэнэ.

4.6. Энэ журмын 4.5-д заасны дагуу Супер сугалааны тохирол тодруулах найман бөмбөлөгийн цифр нь сугалааны дугаарын найман цифртэй дараалал болон тоон утгаараа тохирч байвал Супер сугалааны тохирлын урамшууллыг олгоно.

4.7. Энэ журмын 4.5-д заасны дагуу Үндсэн сугалааны тохирол тодруулах найман бөмбөлөгийн цифр нь сугалааны дугаарын цифртэй дараах байдлаар тохирч байвал Үндсэн сугалааны тохирлоор урамшуулал олгоно:

4.7.1. Сугалааны дугаарын найман цифр нь энэ журмын 4.7-д зааснаар тодруулсан найман цифртэй дараалал болон утгаараа тохирч байвал 1 дүгээр зэргийн урамшууллыг;

4.7.2. Сугалааны дугаарын сүүлийн долоон цифр нь энэ журмын 4.7-д зааснаар тодруулсан сүүлийн долоон цифртэй дараалал болон утгаараа таарч байвал 2 дугаар зэргийн урамшууллыг;

4.7.3. Сугалааны дугаарын сүүлийн зургаан цифр нь энэ журмын 4.7-д зааснаар тодруулсан сүүлийн зургаан цифртэй дараалал болон утгаараа таарч байвал 3 дугаар зэргийн урамшууллыг;

4.7.4. Сугалааны дугаарын сүүлийн таван цифр нь энэ журмын 4.7-д зааснаар тодруулсан сүүлийн таван цифртэй дараалал болон утгаараа таарч байвал 4 дүгээр зэргийн урамшууллыг;

4.7.5. Сугалааны дугаарын сүүлийн дөрвөн цифр нь энэ журмын 4.7-д зааснаар тодруулсан сүүлийн дөрвөн цифртэй дараалал болон утгаараа таарч байвал 5 дугаар зэргийн урамшууллыг;

4.7.6. Сугалааны дугаарын аливаа сүүлийн гурван цифр нь энэ журмын 4.7-д зааснаар тодруулсан сүүлийн гурван цифртэй дараалал болон утгаараа таарч байвал 6 дугаар зэргийн урамшууллыг.

4.8. Сугалааны урамшуулал болон сугалааны дугаарыг нэгдсэн системийн хэрэглэгчийн хэсэгт бүртгүүлсэн сугалаанд оролцогчид олгоно.

4.9. Сугалааны тохирлыг зөвхөн өмнөх сард хэвлэгдсэн сугалааны тасалбаруудаас тодруулна.

4.10. Энэ журмын дагуу сугалааны хонжвор таарч урамшуулал авах эрхтэй сугалаанд оролцогч нь тохирол явагдсанаас хойш 90 хоногийн хугацаанд урамшууллаа авах эрхтэй бөгөөд уг хугацаа өнгөрсөн бол тухайн этгээдийг сугалааны урамшууллаас татгалзсанд тооцно.

4.11. Супер урамшуулал олгох сугалааны тасалбар тодроогүй тохиолдолд тухайн урамшууллын дүнг дараа сарын супер урамшууллын дүн дээр нэмэх зарчмаар дараагийн супер урамшууллын хэмжээг нэмэгдүүлж олгоно.

4.12. Сугалааны дугаарын сүүлийн орноос эхлэн сугалааны тохирлын дугаарыг тодруулна.

## **Тав. СУГАЛААНЫ УРАМШУУЛАЛ БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ**

5.1. Сугалааны урамшуулал болон сугалаа явуулах үйл ажиллагааны зардал нь улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг байна.

5.2. Тухайн жилд олгох сугалааны урамшууллын хэмжээ, супер болон үндсэн сугалааны урамшууллын хэмжээг жил бүрийн эхний сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **Зургаа. СУГАЛААНЫ ТОХИРОЛ ЯВУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

6.1. Сугалааны тохирол явуулах үйл ажиллагаанд хяналт тавих бүрэлдэхүүнийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батлана.

6.2. Хяналт тавих бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөлөл оролцоно.

6.2.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

6.2.2. Авлигатай тэмцэх газар;

6.2.3. Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

6.2.4. Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

6.2.5. Цагдаагийн төв байгууллага;

6.2.6. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар;

6.2.7. Иргэдийн төлөөлөл;

6.3. Энэхүү журмын 6.2-т заасан төлөөллийг тухайн байгууллага болон иргэнээс бичгээр өгсөн хүсэлтийг үндэслэн бүрэлдэхүүнд томилно.

6.4. Хяналт тавих бүрэлдэхүүн нь сугалааны тохирол явуулах үйл ажиллагаанд дараах хяналтыг хийнэ:

6.4.1. Холбогдох хууль, журамд нийцэж байгаа эсэх;

6.4.2. Ил тод, шударга явагдаж байгаа эсэх;

6.4.3. Хөндлөнгийн нөлөө болон зөрчил байгаа эсэх;

6.4.4. Тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд;



6.5. Сугалааны тохирол явуулах танхим (цаашид “танхим” гэх) дараах нөхцөлийг хангасан байна:

6.5.1. Танхим нь сугалааны тохирол явуулахаас 8-аас багагүй цагийн өмнө бэлэн байх;

6.5.2. Сугалааны тохирол явуулах үйл ажиллагаанд хяналт тавих бүрэлдэхүүн ажиллах нөхцөлөөр хангасан байх;

6.5.3. Сугалааны тохирол явуулах үйл ажиллагааг шууд дамжуулах, хянах нөхцөлд 3-аас доошгүй талаас бичлэг хийх боломжтой камер болон дагалдах тоног төхөөрөмжийг суурилуулсан байх;

6.5.4. сугалааны урамшуулалын тохирол тааруулах бөмбөлөг бүхий сугалааны машин суурилуулсан байх;

6.6. Сугалаа явуулах үйл ажиллагааг орон даяар сар бүрийн гурав дахь ням гаригт Улаанбаатар хотын цагын бүсийн 19:00 цагт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулна.

6.7. Сугалааны тохиролыг энэхүү журмын 6.5.4-д заасан сугалааны машинаар тодруулна.

6.8. Сугалааны тохирол явуулах үйл ажиллагааг танхимд суурилуулсан камер болон бусад тоног төхөөрөмжөөр бүрэн баримтжуулна.

6.9. Сугалааны машинаас гарах бөмбөлөг бүрийн цифрийн дугаарыг дэлгэцээр тодруулж харуулна.

6.10. Сугалааны тохирол явуулах машин нь тунгалаг хоргон бүтэцтэй байх бөгөөд тус хоргонд тэгээс ес хүртэлх цифрийн дугаарлалт бүхий бөмбөлгүүдийг байрлуулна.

6.11. Сугалааны тохирлын мэдээллийн татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь албан ёсны цахим хуудсаар мэдээлнэ.

## **Долоо. СУГАЛААНЫ ТОХИРЛЫН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

7.1. Сугалаанд оролцогч нь сугалааны тохирлоор хожсон урамшууллаа энэ журмын 4.10-т заасан хугацаанд багтаан дараах харьяаллын дагуу хүсэлт гаргаж, баталгаажуулна:

7.1.1. сугалааны тохирлын урамшууллын хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөг хүртэлх бол нэгдсэн системийн хэрэглэгчийн хэсэгт сугалааны тохирлын урамшуулал авах хүсэлтээ бүртгүүлнэ.

7.1.2. сугалааны тохирлын урамшууллын хэмжээ 500,000 (таван зуун мянга) төгрөг буюу түүнээс дээш бол харьяалах татварын албанд биечлэн очиж, холбогдох сугалааны тасалбар, иргэний үнэмлэх түүнтэй адилтгах баримт бичгийг хүсэлтийн хамт гаргаж өгнө.

7.2 Татварын алба нь энэ журмын 7.1-д зааснаар ирүүлсэн хүсэлтийг тулган баталгаалж, ажлын 7 хоногт багтаан татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

7.3 Энэ журмын 7.1-д заасны дагуу хүсэлтээ баталгаажуулсан сугалаанд оролцогчийн сугалааны тохирлыг хэрэглэгчийн хэсэгт бүртгүүлсэн дансны дугаараар ийнхүү хүсэлт гаргаснаас хойш ажлын 20 хоногийн дотор олгоно.

7.4 Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төрийн санд сугалааны урамшуулал олгох тусгай данстай байна.

7.5 Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сугалааны урамшууллаар олгох мөнгөн дүн, мэдээлэл, хэмжээний саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.

7.6 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн сангийн нэгж урамшуулалын санхүүжилтийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тусгай дансанд санхүүжүүлнэ.

7.7 Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тусгай дансанд урамшуулалын санхүүжилт орсноос хойш ажлийн 3 өдөрт багтаан Төрийн сангийн үйл ажиллагааны журамд заасны дагуу Төлбөрийн хүсэлт /ТТ1 маягт/ болон файлыг Төрийн санд ирүүлэн гүйлгээг хийнэ. Төлбөрийн хүсэлтэд доорх мэдээллийг үнэн зөв, гүйцэд бөглөсөн байна.

- 7.5.1. Хүлээн авагчийн нэр;
- 7.5.2. Хүлээн авагчийн регистрийн дугаар;
- 7.5.3. Хүлээн авагчийн банк;
- 7.5.4. Хүлээн авагчийн дансны дугаар;
- 7.5.5. Мөнгөн дүн.

7.8 Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сугалааны урамшууллыг Төрийн сан дахь тусгай дансаар дамжуулан сугалааны азтан тус бүрийн дансанд шилжүүлнэ.

7.9 Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улирал бүрийн эцэст тооцоо хийн тусгай данс үлдэгдэлтэй бол санхүүжилт хийсэн дансруу буцаан төвлөрүүлнэ.

7.10 Сугалааны тохиролоор тухайн төрлийн урамшуулалд 2 буюу түүнээс дээш тооны азтан шалгарсан тохиолдолд тухайн төрлийн урамшууллын санд тусгасан мөнгөн дүнг тухайн төрлийн нийт азтаны тоонд тэнцүү хувааж олгоно.

7.11 Сугалааны тасалбарыг хэрэглэгчийн хэсэгт бүртгүүлсэн сугалаанд оролцогч нь тус сугалааны анхны эзэмшигч байна.

7.12 Сугалааны тохирол тодруулах арга хэмжээний хүрээнд азтан тодроогүй бол тухайн сарыг азтанг нөхөн тодруулахгүй.

7.13 Тохирол таарсан сугалааны тасалбарыг хоёр буюу түүнээс дээш этгээд эзэмшиж байгаа талаар маргаан үүссэн тохиолдолд анхны эзэмшигч нь

тохирол таарсан сугалааны хууль ёсны эзэмшигч байх ба түүнд холбогдох тохирлыг өгнө.

### Найм. БУСАД

8.1. Сугалааг зогсоосон, сугалааны тохирол явуулах зарласан хугацаа хэтэрсэн нь сугалааны тохиролыг зохион байгуулах, урамшууллыг олгох үүргээс чөлөөлөхгүй.

8.2. Сугалаанд оролцогч нь сугалаазохион байгуулагчаас дараах зүйлсийг шаардах эрхтэй:

8.2.1.сугалааны нөхцөлтэй холбогдуулан мэдээлэл шаардах;

8.2.2.сугалааны тасалбарыг үндэслэн хонжворыг олгохыг шаардах.

8.3. Сугалааны тохирол тодруулахаас татгалзсан тохиолдолд үндэслэлээ тайлбарлах бөгөөд сугалаатай холбоотой маргаан гарвал дараах газруудаас тодруулна.

8.3.1. Сугалаанд оролцогчийн худалдан авалтын мэдээлэл нэгдсэн системд 72 цагийн дотор ирээгүй тохиолдолд борлуулагчаас тодруулах;

8.3.2. Сугалааны урамшууллын зохион байгуулалттай холбоотой маргааныг сугалаа зохион байгуулагчаас тодруулах;

8.3.3. Урамшууллыг олгохтой холбоотой маргааныг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргаан байгууллагаас тодруулах.

---oOo---